



Дэлхийн театрын өдрийн Захидал 2025 оны 3-р сарын 27

Захидлыг бичигч: Феодор ТЕРЗОПОЛ, Грек улс

Театрын найруулагч, Сурган хүмүүжүүлэгч, Зохиолч, Аттис театрын үүсгэн байгуулагч ба уран сайхны удирдаач, Театр олимпийг санаачлагч ба Театр олимпийн Олон улсын хорооны тэргүүн

Монгол (Орчуулга)

Дэлхийн театрын өдөр 2025-д зориулсан Феодор ТЕРЗОПОЛ-ын Захидал

Театр сонсож чадах болов уу? Бидний оршин буй цаг үеийн, боомилон буй хувийн орон зайдаа дарангуйлагдсан, виртуал бодит байдлын шоронд түгжигдэн бүхий л талаараа үгүйрэн хоосорч буй ертөнц дэх иргэдийн аврал эрсэн дуудлагыг? Амьдралын бүхий л хүрээг хамарсан хатуу хяналт, дарангуйллын тоталитар тогтолцоон дахь роботжсон оршихуйн ертөнцөд сонсож үнэхээр чадах уу?

Театрын хувьд, экологийн сүйрэл, дэлхийн дулаарал, үй олон биологийн төрөл зүйл устан үгүй болох, далай тэнгисийн бохирдол, мөнх цаст уулсын цас хайлан урсах эсхүл ойр ойрхон тохиох болсон ойн түймэр ба цаг уурын эрс тэс үзэгдлүүд гэх мэт асуудал санаа зовних асуудал мөн үү? Театр экосистемийн идэвхтэй хэсэг байж ер нь чадах уу? Хүн төрөлхтний байгаль дэлхийд үзүүлж буй сөрөг нөлөөллийг театр олон жилийн түрш харж ажигласаар ирсэн, гэвч энэ асуудлыг шийдвэрлэхэд үнэндээ хүчин мөхөсдөж бэрхшээлтэй байнга тулгарсаар байна.

Иргэдийн бодол санааг улс төр, эдийн засгийн ашиг сонирхлын бүлгүүд, мэдээллийн сүлжээ ашиглан нийгмийн сэтгэл зүй, санаа бодлыг зориудаар төөрөгдүүлэгч компаниуд зориуд төөрөгдүүлэн тааллаараа залах болсон 21-р зуунд хүн төрөлхтний нөхцөл байдлын талаар театр үнэхээр санаа зовниж байгаа болов уу? Нийгмийн сүлжээ нь харилцааг хөнгөвчилж байгаа шигээ харилцааны хувьд Өөр бусдаас ангид аюулгүй байх зайлшгүй хэрэгцээг хангах баталгаа болж чадах уу? Өөр бусдаас буюу өөрөөсөө өөр хэн нэгнээс, Үл таних этгээдээс айх асар их айдас нь бидний бодол санаа, үйлдлийг дарангуйлан ноёлж байна.

Цус асгаруулсан гашуун түүхээ сөхөлгүй өөр хоорондоо ялгаатай байдлаа хадгалан зэрэгцэн оршиход туслах үүргийг театр гүйцэтгэж чадах уу?

Цус асгаруулсан гашуун түүх биднийг Домгийн ертөнцийг сэргээхэд уриалан дууддаг. Хайнер Мюллерын хэлснээр “Домог гэдэг нь цогцолбор, өөрөөр хэлбэл үргэлж шинэ болон

хуучин эд ангиудыг хооронд нь холбож байдаг машин. Соёлын салбарт тэсрэх хүртэл нь хурдыг нь нэмэгдүүлэх энерги дамжуулагч бол энэ мөн”. Үүн дээр би харанхуй, мунхаг байдлын талбар гээд нэмээд хэлчихмээр байна.

Нийгмийн гэмтлийг илчлэн театр гэрэл тусгаж чадах уу? Өөрийгөө хүртэл төөрөгдүүлэн буй гэрлээ унтрааж чадах болов уу?

Эдгээр асуултад тодорхой хариу гэж үгүй, угаасаа ч байх боломжгүй юм, учир нь энэ л хариу үгүй асуултууд байгаа учир театр оршин байж, элдэв шалгуурыг даван бат нот оршоор байдаг юм.

Дионисийн өдөөсөн асуултууд түүний төрсөн нутгаас эхлээд эртний театрын найрал хөгжмөөр дамжин дайн дажин бүхий үүл нурууд, ус голыг гатлан өдгөө чимээгүй дүрвэн буй дүрвэгсдийн аялалаар үргэлжилсээр Дэлхийн театрын өдөртэй золгож байна.

Өнгөрсөн, одоо ба ирээдүйг нэгтгэгч, Зевс болон Семелийн хоёронтоо төрсөн хүү, эр хийгээд эм аль ч хүйсэд үл захирагдан өөрийгөө илэрхийлэгч, үүр хилэн хийгээд энэрэлт сэтгэл, аугаа бүрхны хийгээд адгуусны шинжийн аль алиныг нь агуулагч, галзуурал хийгээд мэргэн ухааны заагт оршигч, эмх цэгц болоод замбараагүй байдлыг бий болгогч, амьдрал үхлийн заагт наадагч, домог хийгээд театрын бурхан Дионисийн нүд өөд эгцлэн харцгаая. “Энэ бүхэн ямар учир утгатай вэ?” хэмээх онтологийн суурь асуултыг Дионис бидэнд тавьж, бүтээгч хэн бүхнийг домгийн гүн рүү улам бүр шумбан орж судлах, хүний тайлагдаагүй олон нууцад гүнзгий нэвтрэн орохыг уриалан дуудаж залан чиглүүлж байна.

Одоо цагийн Дундад эрин үеийн олон хэлбэрт дарангуйллаас гарахад хөтлөх ёс суртахууны болоод улс төрийн шинэ үүрэг хариуцлагыг бий болгох, ой санамжийг хөгжүүлэхэд чиглэсэн шинэ арга замууд бидэнд гарцаагүй хэрэгтэй.

Феодор Терзопол

Англи хэлнээс орчуулсан: Н.Болороо / ОУТИ-ийн Монголын төв